

Усны нөөцийг хамгаалах талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Монгол орны усны нөөцийн хомсдол, бохирдлын өнөөгийн байдал, цаашид баримтлах чиглэл”-ийн тухай Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газарт:

1.Газрын доорхи усны хяналт-шинжилгээний сүлжээг Монгол орны байгалийн бүсүүдийг хамруулан байгуулах, газрын доорхи ус болон рашааны ордыг паспортжуулж, улсын усны мэдээллийн цахим сан бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх.

2.Газрын доорхи усны нөөцийг үнэлэх аргачлалыг шинэчлэн боловсруулж, усны ордуудын нөөцийг дахин үнэлэх, Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрүүдийн нөхөн сэргэлтийн болон харилцан нөлөөллийн үнэлгээг хийх, ашиглалтын хэтийн төлөвийг оновчтой тодорхойлох ажлыг даруй зохион байгуулах.

3.Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийх, түүнээс гарсан цэвэршүүлсэн усыг эргүүлэн ашиглах төслийг ойрын хугацаанд хэрэгжүүлэх.

4.Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн Монгол орны экосистемийн хямрал, түүний үр дагаврыг сайтар тооцож, ойрын болон холын ирээдүйд учирч болзошгүй эрсдэлд үнэлгээ өгсний үндсэн дээр гадаргын усны нөөцийн хуримтлалыг бий

болгон ашиглах зорилгоор “Орхон-Говь”, “Туул-Сэлбийн хөгжил” төслүүдийг эхлүүлэх арга хэмжээ авах.

5.Тэргүүн ээлжинд усны нөөц багатай говь, хээрийн бүсэд ахуйн болон үйлдвэрлэлийн бохир усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглах, эко жорлонг гэр хороололд хэрэглүүлж занших арга хэмжээг зохион байгуулах.